

## Хүрээний түүхийн он дараалал (1691-1911)

1. 1700 Эрдэнэ зууг засаж их чуулган хийв (Амарбаяр С. 2014, 49).
2. 1706 Эрдэнэ зууд чуулган хийж сум, хамжлага хуваав.
3. 1706-1719 Их Хүрээ Эрдэнэ Толгойд (Архангай аймгийн Түвшрүүлэх сум) байв.
4. 1712 оны 7 сар. Манжийн Торгуудын хант улсад зарсан элчин сайд Түлишэн одоогийн Улаанбаатар хот байгаа газарт Туул голын үерт боогдож хэдэн өдөр өнжиж, загас барьж, буга намнаж байжээ.<sup>1</sup>
5. 1719 Их Хүрээ Дааган дэлд (Хэнтий аймгийн Ерөө сум) буув (Дүрзээ 2021,12).
6. 1720-1722 Усан сээрийн гол
7. 1722-1723 Их Тамирын гол
8. 1723-1724 Жаргалант
9. 1723. Хт 14. Өндөр гэгээн Занабазар (1635-1723) жанч халав.
10. 1724 II Богд тодров.
11. 1724-1725 Ивэн голын эх
12. 1725-1729 Орхон Ивэнгийн бэлчир
13. 1727 Буурын гэрээ байгуулж, хойд хилийг тогтоов.
14. 1729-1730 Жаргалантын дэнж
15. 1731 Бяцхан хутагт II Богдыг Долоннуурт шилжүүлэн суулгав.
16. 1730-1732 Бургалтайн Хөх овоо
17. 1732 оны 5 сарын 20. Хүрээнд сүм бариулахаар батламж гаргав.
18. 1732-1733 Сөгнөгөрийн ам
19. 1733-1734 Тэрэлжийн Бумбат-Ухаа
20. 1734-1736 Улиастайн аманд
21. 1736-1740 Хүй Мандал
22. 1740-1742 Хунцалын эх
23. 1741 он. II Богд Долоннуураас нүүж Хүрээнд ирэв.
24. 1741 он. II Богдыг харгалзах хоёр манж хиаг Хүрээнд ирүүлэв.
25. 1742-1743 Үдлэгийн эх
26. 1743-1747 Өгөөмөрийн хөндий
27. 1747-1762 Сэлбийн голын дэнж
28. 1762-1771 Туул гол
29. 1761 он Түшээт хан Цэдэндорж Их Хүрээнд байх болов.
30. 1772.зд 2-1778 Хүй голын Мандал<sup>2</sup>
31. 1778 оноос Хүн чулууны хонхор<sup>3</sup>
32. 1757 онд II Богд таалал төгсөв.
33. 1758 Халхын түшээт хан аймгийн туслагч жанжин Санжайдорж Хүрээний хэргийг эрхэлж эхлэв.
34. 1761 Хүрээнд манж сайд сууж эхлэв.
35. 1763 он. Хүрээний худалдааны хороог шалгав
36. 1767 он Улиастайн жанжин Цэнгүнжав (1700-1771) Их Хүрээнд ирэв.
37. 1768 Хиагтын гэрээний нэмэлт өөрчлөлт хийхээр бэлтгэв.
38. 1768.9.20 Монгол ноёд, хутагт хувилгаад Оростой худалдаа хийх дүрэм тогтоов.
39. 1772.3.25. Хамба номун хан Лувсанжамбал Хүрээг Хүйн голын Мандалд шилжүүлхийг гуйж сайдад айлтгав.
40. 1772.3.25. Хүйн Мандалд Оросын элчийг Хүрээний сайд хүлээн авах хэдэн өрөө байшин бариулхыг зөвшөөрөв.
41. 1772.4.20. Хүйн Мандалд Их Хүрээг засахдаа Лам нар, Харчууд дүүргийг салгаж буулгахаар дүрэм тогтоов.

<sup>1</sup> Tulišen. Lakcaha bade takūraha babe ejehe bithe.

<sup>2</sup> Хүрээг нүүлгэх тухай эрдэнэ шанзодба Дамчойравжай нарын өргөх бичиг - Ганцэцэг Ц, нар (эмхэт), З.Лонжид (ред.). Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын түүхэнд холбогдох баримтын эмхэтгэл. Нэгдүгээр боть. УБ.,2018, т67.

<sup>3</sup> Дүрзээ Ч. Улсын нийслэл Улаанбаатар хот: Түүхэн он дарааллын бичиг. УБ 2021. т18.

42. 1778 Их Хүрээ одоогийн Улаанбаатар хот байгаа нутагт нүүж ирэв.
43. 1778 оны 8 сар. Хүрээний сайд бөгөөд Халхын ван Санжайдорж Богд Хан уулыг дархан цаазтай болгохоор олон ноёд хутагттай хэлэлцэж тогтоод Манж хаанд айлтгав.
44. 1778 оны 11 сар. Хүрээний сайд Санжайдорж нас барав.
45. 1778 оны 12 сар. Түшээт хан Цэдэндорж Их Хүрээний сайд болов.
46. 1779 он. Түшээт хан бөгөөд Хүрээний сайд Цэдэндорж Богд Хан уулыг тахилгатай болгох Санжайдоржийн саналыг давтан айлтгав.
47. 1783 он. Жүн ван Юндэндорж Хүрээний сурч хэрэг шийтгэх сайд болов.
48. 1793 он. Хүрээний ойролцоо Баянзүрх ууланд Хүрээг хамгаалах 200 цэргийг авлан боловсруулав.
49. 1794 он. Хүрээний ойролцоо Баянзүрх ууланд Хүрээг хамгаалах 200 цэргийг авлан боловсруулав.
50. 1796 он. Хүрээний харъяат 200 цэргийг авлан боловсруулав.
51. 1797 оны 12 сарын 27. IV Богддод алба хааж байгаа сойвон, гэвхүй нараас хаалгач соёгба хүртэл тушаалтныг бүртгэн тодорхойлжээ.
52. 1802 он. Хүрээний сайд Юндэндорж Түшээт хан, Цэцэн хан хоёр аймгийн чуулганыг Хүрээний сайдад захируулхаар айлтгав.
53. 1802 он. Хүрээнд сууж хэрэг шийтгэгч Сайдын яамыг байгуулав.
54. 1805 Оросын элчин сайд сенатор гүн Головкин Их Хүрээнд ирэв.
55. 1806 Оросын элчин сайд сенатор гүн Головкин Их Хүрээнээс Санктпетербург руу буцав.
56. 1811 Их Хүрээнд цам харайж эхлэв. 1811-1937 хүртэл 127 удаа Хүрээнд цам бүжиж байжээ (Karénina Kollmar-Paulenz 2015).
57. 1813 он. IV Богд жанч халав.
58. 1819 онд олон аймгийн ноёд Хүрээнд чуулж Бат-Оршил өргөх баяр хийгээд Хэнтий хан уулыг тахилгатай болгохоор шийджээ.
59. 1820 он. Хүрээний сайд Юндэндорж, Хүрээний өмнөх Богд Хан уул болон Хэнтий хан ууланд ан хийх, мод тайрхыг хориглох хууль санаачилжээ.
60. 1832 оны 11 сарын 11. Хүрээн дэх ноёдын харъяат Харчуудыг бүртгэжээ.
61. 1859 он. Хүрээний монгол сайд Дэлэгдоржийн орон тооны зэргийг бууруулж, Манж сайд тэргүүлэх болгожээ.
62. 1860 оны хавар. Цэцэн хан аймгийн 1000 цэргийг Хүрээний оролцоо хамгаалан суулгажээ.
63. 1862 он зуны сүүл сарын 26. Цэцэн хан аймгийн Хүрээг хамгаалах 1000 цэргийн Хонхонд суулгасан ангийн цэргүүдийг бүртгэжээ.
64. 1865 оны 12 сарын 12. Их Хүрээний Харчууд, Наймаачин дүүрэгт оршин суугчдыг бүртгэжээ.
65. 1866 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
66. 1867 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
67. 1868 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
68. 1869 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
69. 1870 оны 10 сарын 2. Хүрээг хамгаалах цэргийн эр, цэргийн зэвсэгийг хуваажээ.
70. 1870 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
71. 1871 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
72. 1872 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
73. 1873 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.

74. 1873 оны 10 сарын 30. Их Хүрээ, Гандандэгчилэн хүрээ, Даян хүрээ, Шашныг бадруулагч хүрээ, Бишрэлт сүм, Буяныг залбирагч сүм, Дашсамлан дацанд хурал сургууль үйлдэж буй хуврага лам нар, гэрийн тоог тодорхойлон бүртгэжээ.
75. 1874 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
76. 1875 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
77. 1876 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
78. 1877 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
79. 1878 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
80. 1880 оны 7 сарын 10. Түшээт хан аймагт Их Хүрээг хамгаалах 2000 цэрэг хуралдуулж, 4 анги хувааж, захирах түшмэл цэргийн нэр цалинг тодорхойлжээ.
81. 1880 оны зуны дунд сарын 16. Цэцэн хан аймгаас Их Хүрээг хамгаалах 2000 цэрэг хуралдуулж, 4 анги хувааж, захирах түшмэл цэргийн нэр цалинг тодорхойлжээ.
82. 1880 оны 8 сарын 19. Түшээт хан аймгийн цэргийн 3-р хороог бүртгэж тодорхойлжээ.
83. 1880 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
84. 1881 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
85. 1882 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
86. 1883 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
87. 1886 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
88. 1891 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
89. 1893 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
90. 1899 он. Халхын 4 аймгийн ноёд, шавийн хутагт хувилгаад Монгол газарт алт ухуулахгүй гэж шийдвэрлэжээ.
91. 1900 оны 6 сарын 17. Нийтээр Бат-Оршиллын баяр тэмдэглэв.
92. 1901 оны 3 сар. Манжийн хааны угсааны гүн Их Хүрээнд ирж уурхай эсэргүүцсэн ноёдтой чуулган хийгээд, Уурхай нээхийг түтгэлзэж шийджээ.
93. 1905 оны 12 сар. Английн цэрэг Төвдийг эзэлсэн тул Далай ламыг Их Хүрээнд суулгана уу гэж гуйжээ.
94. 1905 оны 11 сар. Их Хүрээнд Далай ламын сүм бариулах учрыг VIII Богдод мэдэгджээ.
95. 1905 оны 12 сар. Далай лам Их Хүрээнд сүм бариульа гэж айлтгажээ.
96. 1905 оны 12 сарын 29. Далай ламтай уулзахад Богд гэгээний ширээ сэнтийг хэрхэн бэлтгэхийг зөвлөжээ.
97. 1906 оны 2 сарын 3. Далай ламыг Их Хүрээнд ирхэд Хүрээний сайд тосохдоо унах гочоо, алшаа, жороо морьдыг уяж бэлтгэхийг тушаажээ.
98. 1906 оны 2 сарын 7. Далай лам болон дагалдагчидад нь хүнс гурил хүргүүлжээ.
99. 1906 оны 2 сарын 10. Далай лам Богд гэгээний ширээг зэрэгцээ чацуу бэлтгэх эсхийг зөвлөлджээ.
100. 1906 оны 4 сарын 23. Далай лам товлосон цагт явж үл чадах тул үлдэхийг хүсэж Хүрээний сайдад бичиг өргөжээ.
101. 1906 оны 5 сарын 20. Далай лам Хүрээнд залархад ширээ сэнтийг хэрхэн бэлтгэх тухай зөвлөлджээ.

102. 1908 он Монгол газарт Алтны уурхай нээх хэргийг зөвшөөрхийг Хүрээний сайд Пунцагцэрэнд тушаажээ.
103. 1908 он. Улиастай гол дахь VIII Богдын орд гэрийн орчим, орос хятадын суурьшил бий болж байгааг зогсоох хүсэлт гаргав.
104. 1908 он. Зүүнхүрээ, Гандандэгчилэн хийдийн хооронд хог хаясан хятадаар хогийг цэвэрлүүлж, хог орхихыг хоригложээ.
105. 1910 он. Харчууд, Наймаачин дүүрэгт суугаа Шавийн харъяат нарыг бүртгэжээ.
106. 1911.11.30 Халхын Хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар байгуулагджээ.
107. 1912.12.1 Манжийн сүүлчийн сайдыг Их Хүрээнээс хөөн гаргажээ.

**ХҮРЭЭНИЙ ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ ШИНЭЭР ИЛРҮҮЛСЭН  
БАРИМТЫН ЖАГСААЛТ  
(илрүүлсэн баримт 1960 хуудас, ихэвчлэн манж баримт)**

1. Saicungga Fengšen-i nadaci aniya-de eiten wesimbuhe baitai sarkiyān dangse - Хүрээний сайдад аймгийн чуулгануудыг нэгтгэж, Хүрээний сайдын газар байгуулхыг хүссэн Юндэндоржийн айлтгал. 1803 [М-1. Д-1. Хн611. Т186-190]

**Хүрээний нүүдэл ба дүүргүүдийн тухай**

1. Хамба номун хан Лувсанжамбал нараас хутагтын Хүрээ нэг газраа удсан тул Хүй голын Мандалд шилжүүлэн суулгаж болох уу хэмээн гуйн айлтгасанд зарлиг ёсоор болго хэмээснийг Хүрээ сайдын тамгын газраас даган явуулсугай хэмээн тушаасан бичиг. *ТТ37 [1772] 3 сарын 25* [ М-1, Д-1, ХН-289, тал 64-67]
2. Хүрээг шинээр шилжүүлэх Хүйгийн газарт Орос элч нарыг хүлээн авах хэдэн өрөө модон гэр бариулахыг гуйн айлтгасан учир зарлиг ёсоор болго хэмээснийг Түшээт хан Цэдэндорж, шанзудба Дамчойравжай нарт Хүрээ сайдын тамгын газраас тушаасан бичиг. *ТТ37 [1772] 3 сарын 25* [ М-1, Д-1, ХН-289, тал 56-57]
3. Хүрээний сайдын тамгын газраас, цаг тооны бичгийг Хүрээний хоёр этгээдийг захирах туслагч Очирбат нарт олгосон тухай. *СЕ24 оны 12 сарын шинийн 19.* [М-1 Д-1 Хн-785. тал 208-209]
4. Хүрээ сайдын тамгын газраас, Хүрээг Хүй мандалд шилжүүлэх учир шилжсэн Хүрээнээс Харчуудыг хол суулгах, Харчууд дотор лам нар суулгахгүй байх зэргийг тодорхойлон шанзудба Дамчойравжай нарт цаазлан тушаасан бичиг. *ТТ37 [1772] 4 сарын 20* [ М-1, Д-1, ХН-289, тал 85-86]
5. Төр гэрэлтийн арван хоёрдугаар онд хүрээний хавь ноёдын харчуудыг байцааж өргөсөн дэвтэр. *ТГ12[1832] 11 сарын 11.* [М-1 Д-1 Хн-95. Тал 1-66]
6. Бүрэнт засагчийн дөрөвдүгээр он Харчууд, Маймаа хотын зэрэг газруудад суугаа ардыг байцааж үйлдсэн дэвтэр. *Б34[1865] 12 сарын 12*(М-1 Д-1 Хн-1535. Тал 1-66)
7. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отогын өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *Б3 5 он.* [1866] [М-1 Д-1 Хн-1557 Тал 1-60]
8. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отогын өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *Б3 6 он.* [1867] [М-1 Д-1 Хн-1574. Тал 1-61]
9. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отогын өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *Б3 8 он.*[1869] [М-1 Д-1 Хн-1628. Тал 1-65]
10. Бүрэнт засагчийн есдүгээр онд Харчууд, Маймаа хотын зэрэг газар суугаа ардыг байцааж үйлдсэн дэвтэр. *Б39 [1870] он.* ( М-1 Д-1 Хн-1641. Тал 1-59)
11. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отогын өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *Б3 10 он.* [1871] [М-1 Д-1 Хн-1674. Тал 1-54]
12. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отогын өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *Б3 11 он.* [1872] [М-1 Д-1 Хн-1697. Тал 1-55]

13. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отогын өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *БЗ 12 он*. [1873] [М-1 Д-1 Хн-1716. Тал 1-46]
14. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отогын өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *БЗ 13 он. 12 сарын 18*. [1874] [М-1 Д-1 Хн-1739. Тал 1-48]
15. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отгийн өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *БТ1* [1875] *12 сарын 16*. [М-1 Д-1 Хн-1755. Тал 1-47]
16. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отгийн өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *БТ2* [1876] *12 сар*. [М-1 Д-1 Хн-1773. Тал 1-46]
17. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отгийн өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *БТ3* [1877] *12 сарын 17*. [М-1 Д-1 Хн-1794. Тал 1-46]
18. Шавиас Хүрээний Харчууд Маймаа хотын зэрэг газар суугаа ардуудын отгийн өрх, амын байдалыг байцааж үйлдсэн дэвтэр, *БТ4* [1878] *12 сарын 17*. [М-1 Д-1 Хн-1819. Тал 0-50]
19. Бадаргуулт төрийн наймдугаар он өвөл цаг Харчууд ба зах хорио Маймаа хотын зэрэг газар суугаа харъяат шавийн албад албагүй ардуудыг байцааж арван өрх бүр дараалан дарга ажиг байгуулж тогтоон үйлдсэн дэвтэр. *БТ6* [1880] *оны 12 сарын 17*. ( М-1 Д-1 Хн-1868. Тал 1-45)
20. Харчууд Хороо ба Маймаа хотын зэрэг газар харъяат шавийн албатай алба үгүй ардуудыг байцааж дарга ажиг байгуулж тогтоосон дэвтэр, *БТ6* [1880] *12 сарын шинийн 8*. [М-1 Д-1 Хн-2033. Тал 1-46]
21. Харчууд Хороо ба Маймаа хотын зэрэг газар харъяат шавийн албатай алба үгүй ардуудыг байцааж дарга ажиг байгуулж тогтоосон дэвтэр, *БТ7* [1881] *12 сарын 12*. [М-1 Д-1 Хн-2050. Тал 53-92]
22. Харчууд Хороо ба Маймаа хотын зэрэг газар харъяат шавийн албатай алба үгүй ардуудыг байцааж дарга ажиг байгуулж тогтоосон дэвтэр, *БТ8* [1882] *12 сарын 18*. [М-1 Д-1 Хн-1909. Тал 1-42]
23. Харчууд Хороо ба Маймаа хотын зэрэг газар харъяат шавийн албатай алба үгүй ардуудыг байцааж дарга ажиг байгуулж тогтоосон дэвтэр, *БТ9* [1883] *12 сарын 12*. [М-1 Д-1 Хн-1925. Тал 1-40]
24. Бадаргуулт төрийн арван дөрвөдүгээр онд Харчууд хороо ба Маймаа хотын зэрэг газар суугаа шавийн албатай албагүй ардуудыг байцааж дарга ажиг байгуулан тогтоосон дэвтэр. *БТ12*[1886] *оны 12 сарын 10*. ( М-1 Д-1 Хн-2007. Тал 1-47)
25. Харчууд Хороо ба Маймаа хотын зэрэг газар харъяат шавийн албатай алба үгүй ардуудыг байцааж дарга ажиг байгуулж тогтоосон дэвтэр, *БТ17* [1891] *12 сарын 11*. [М-1 Д-1 Хн-2050. Тал 1-50]

26. Харчууд Хороо ба Маймаа хотын зэрэг газар суун шавийн албатай алба үгүй ардуудыг байцааж дарга ажиг байгуулж тогтоосон дэвтэр, *БТ19* [1893] 12 сарын 16. [М-1 Д-1 Хн-2091. Тал 1-49]

27. Жибзундамба хутагтын их сангийн зэрэг газруудад суусан харчуудын нэр, өрх, амыг тодорхойлон үйлдэж өргөсөн дэвтэр. *ХЕ2*[1910] 12 сарын шинийн 10. (М-1 Д-1 Хн-2465. Тал 1-48)

### Уул уурхай ба Далай лам

1. Хүрээний худалдааны иргэдийн хэргийг захиран шийтгэх тэмдэглэгч түшмэл Хинлогоос Гадаад монголын төрийг засах явдлын яамны жигүүрийн сайдын хэргийг хамаарсан мэйрэн занги Фүдэд илгээсэн мэйрэн зангийн тушаасан ёсоор Хүрээний худалдааны хороог шалгахад нуугдаж ирсэн иргэн үгүйг мэдүүлсэн бичиг. *ТТ 28.10 сарын шинийн 03.* [М-1. Д-1. Хн-213. Тал 170-171]
2. Бадаргуулт төрийн хорин тавдугаар оны зургаан сарын арван долооны эрхэм сайн өдрөө Халхын дөрвөн аймаг шавь бүгдээр нийлж Очир дара богд гэгээнтэнээ бат оршил өргөж бүрэн наадам үйлдэхэд цол, дэвсгэрийн зэрэг хишиг хүртээж болох хүмүүсийн нэрс. (*Бадаргуулт төрийн 25 дугаар оны 6 сарын 17. Фм 85. д 1. хн 904. н25. х1-4. Монгол хэлээр*)
3. Түшээт хан аймгийн да жанжин нараас Далай ламыг хүрээний газар ба жанжин чин ван Ха-гийн газраа заларч бүхийд хэрэглэсэн зүйлийг хэрхэн тэгшлэн шийтгэхийг тогтоож хариу ирүүлж хэмээн жанжины тушаал хамтлаж захиар илгээсэн хэрэг. (*Бадаргуулт төрийн 33 дугаар оны 6 сарын 30. Фм 31. д 2. хн 5276. н24. х1-5. Монгол хэлээр*)
4. Хүрээний хамаарсан шанзудба да лам Дашжав нарын газраас багш Жибзундамба хутагтын Улиастай голын газарт урьд байгуулсан байшин гэрийн ойр тойрон иргэн, орос, монголчуудын адуу мал адуулан нутаглан бүхий хүмүүсийг зайлуулан нүүлгэж өөр газарт нутаглуулбаас болох уу хэмээн мэдэгдэж ирсэн хэрэг /*Хутагтын гэр байшингийн дэргэд монгол иргэд, орос консулын мал, Шуан хуа цэргийн агт бэлчихийг болиулж нутаг хуваарилах тухай*/ (*Бадаргуулт төрийн 33 дугаар оны 5 сарын 14. Фм 1. д 1. хн 7463. н7. х1-10. Манж хэлээр*)
5. Хүрээний эрдэнэ шанзудба Бадамдорж нарын газраас хүрээний баруун этгээдэд суун бүхий олон пүүсийн иргэдийг Зүүн хүрээ Гандандэгчилэн хоёр сүмийн хооронд орхисон хогийг түүгээр иргэдээр нүүлгэн засуулж хог орхихыг цаазлан дагаж явуулбаас болох уу хэмээн мэдэгдэж ирсэн хэрэг/*Хог буртаг хүн явах замыг боогдуулан бүхийн дээр Майдар бурханы Их хүрээг эргэх цаг учир пүүсийн иргэдээр хогийг цэвэрлэж цаазлахыг шаардсан бичиг*/ (*Бадаргуулт төрийн 33 дугаар оны 3 сарын 29. Фм 1. д 1. хн 7464. н18. х1-15. Монгол хэлээр*)
6. Улиастайн хамаарсан жанжин нарын газраас Далай ламыг хүрээний зэрэг газарт суулган бүхийд хэрэглэсэн зүйлийг дөрвөн аймаг шавьд ялган салгаж тогтоон шийтгэж тушаасан явдлыг хүргэж ирсэн хэрэг. (*Бадаргуулт төрийн 32 дугаар оны 12 сарын 17. Фм 1. д 1. хн 7396. н2. х1-16. Манж, Хятад хэлээр*)
7. Банчин эрдэнийн газраас Богд гэгээн, Далай ламтанаа амгаланг эрхээр ирэгсэдийн суусан байшин хашааны хөлснөөс манай аймгийн хуваарийн мөнгийг лам Бүмд

- өгсөнийг мэдэгдэн тушаасан эх (*Бадаргуулт төрийн 32 дугаар оны 7 сар. Фм 9. д 3. хн 8317. н24. х1-3. Монгол хэлээр*)
8. Тушаалаар гаргасан мэйрэн Наранхүү хүрээ жасаанаас Далай ламтан анх хүрээнд заларч ирээд буцах хүртэл хэрэглүүлсэн зүйлийг таван газар хуваан бодоход харъяат аймагт ноогдсоныг тодорхой данс үйлдэж уг хэргийн бичгүүдийн хамт хүргүүлэв хэмээн жанжин хэбэйгийн тушаал хамт өргөсөн хэрэг (*Бадаргуулт төрийн 32 дугаар оны хаврын сүүл сарын 18. Фм 31. д 2. хн 5197. н1. х1-5. Монгол хэлээр*)
  9. Сайдуудаас зарлигаар зарсан сайд Далай ламтаны газар ирсэн учир яаралтай бичиг элчийг саатуулж үл болох учир тушаасан хэрэг. [*Хүрээний сайдууд илүү дөрвөн сарын хорин зургаанд Далай ламын газар ирэх учир элч хэргийг саатуулж болохгүй хэмээн тушаасан тухай*] (*Бадаргуулт төрийн 32 дугаар оны илүү 4 сарын 29. Фм 9. д 3. хн 8316. н8. х1-6. Монгол хэлээр*)
  10. Далай ламыг дав дув явж чадахгүй зэрэг учрыг гаргаж цахилгаан мэдээгээр айлтгасанд буулгасан зарлигийг тархааж Хан уулын чуулганы дарга нарын зэрэг гурван газарт тушаах хэрэг. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 10 сарын 19. Фм 1. д 1. хн 7339. н26. х1-5. Манж хэлээр*)
  11. Хэбэй ван нарын есөн хошуу суманд Далай ламтан хүрээнээс заларч жанжин чин вангийн хошуу зэрэг газрыг даарин залрахаар тогтоосныг мэдэгдэн тушаасан нь. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 8 сарын 18. Фм 9. д 3. хн 8240. н5. х1-2. Монгол хэлээр*)
  12. Дай бэйсээс Богд, Далай лам нарын залран суух ширээг ямараар засах зэргийг чуулган хуралдаж тулгамдахад хүрэх нь болзошгүй учир урьдаар хөгчлөн томилж төлөвлөн тогтооно уу хэмээн зөвлөж ирсэн хэрэг (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 5 сарын 20. Фм 10. д 2. хн 3369. н9. х1-4. Монгол хэлээр*)
  13. Засаг агсан гүн Мишигдоржийн тамгаас Далай ламтан их хүрээнд заларах тухайн улаа зүйлээс яахан тасалдсан зэрэг учрыг тухайн ерөнхий захирагч Батдэлгэр нараас байцааж мэдүүлсэн хэрэг. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 5 сарын 13. Фм 9. д 3. хн 8240. н49. х1-5. Монгол хэлээр*)
  14. Да бэйстэнд Далай ламтаныг буцаж залрахад өртөө хавсарга улаа бэлтгүүлэхэр зохих газруудад хуваан заларч тушаасан эх нижгээдийг дансанаа авхуулаад хойш хүргүүлэн захиж явуулсан эх. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 5 сарын шинэ. Фм 10. д 2. хн 3369. н11. х1-3. Монгол хэлээр*)
  15. Ши нингийн сайдын газраас Далай ламын өвчин нэмэгдэж энэ дөрвөн сарын хорин дөрвөнд мордож чадахгүй учир биеийн өвчинийг эмчилүүлж илаарь болсон цагт мордохыг хүрээний сайдын зүг түүгээр зөвлөлдөн уламжлан айлтгана уу хэмээн хүргэж ирснийг мэдтүгэй хэмээн хүргэж ирсэн хэрэг (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 4 сарын 23. Фм 1. д 1. хн 7340. н 44. х 1-4. Хятад хэлээр*)
  16. Далай ламын бие өвдсөн учир тогтоосон өдөр мордож чадахгүйг Хүрээний сайдад мэдэгдсэн бичиг. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 4 сарын 22. Фм 1. д 1. хн 7339. н53. х1-2. Манж хэлээр*)



17. Ши нингийн сайд Ян-ы газраас Далай ламын бие энэ жил дөрвөн сарын хорин дөрвөнд Хүрээнээс мордох явдлыг мэдтүгэй хэмээн хүргэж ирсэн хэрэг (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 4 сарын 20. Фм 1. д 1. хн 7340. н30. х1-5. Хятад хэлээр*)
18. Далай ламд дээд зарлиг буулгасан учирт бурхан, хадаг өргөн тэнгэрийн хишигт мөргөсөн явдлыг төлөө айлтгасанд буулгасан зарлигийг тархааж мөнхүү далай ламд явуулах хэрэг. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 3 сар. Фм 1. д 1. хн 7294. н20. х1-4. Манж хэлээр*)
19. Да бэйсэд Далай ламтаны дагалдсан Төвд нарын төлөв зэхий загнах гэмийг хэрхэн ариутгах ба мөнхүү Далай лам Богд гэгээнтнийг залах ширээг тус бүрийн их багийг ямар болгох зэргийг тогтоолгоё хэмээснийг хэрхвээс зохихыг зөвлөн ирсний хариуг захиж явуулсан эх. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 2 сарын 10. Фм 10. д 2. хн 3369. н7. х1-3. Монгол хэлээр*)
20. Гүн Цэдэнсоном нараас Далай ламын уяа морьдыг зарлахад суурин жасааны уяа морьдоос хирд оруулахыг хоцрогдуулсан захирагч Ишдоржийг байцааж мэдүүлсэн хэрэг. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 2 сарын шинийн 9. Фм 9. д 3. хн 8240. н12. х1-4. Монгол хэлээр*)
21. Түшээт хан нарын гурван хошуу суурин жасаанд далай ламтаныг харгалзаж манж сайдын уяа гочоо алшаа морьдыг унуулан тухайд түүгээр бэлтгүүл хэмээн тушаасан эх шугам (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 2 сарын шинийн 3. Фм 9. д 3. хн 8317. н8. х1-5. Монгол хэлээр*)
22. Түшээт хан нарын таван хошуу захирал хафан Дамбад далай ламын санд хүргэх будаа гурилыг ачих улаа зүйлийг гүйцэтгэн бэлтгэж өнгөрүүлэхээр тушаасан хэрэг. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны 2 сарын шинийн 7. Фм 9. д 3. хн 8240. н38. х1-4. Монгол хэлээр*)
23. Да бэйсээс Хүрээний хамба шанзудба нараас Далай лам Богд гэгээнтэнийг залах ширээг тус бүрийн их багийг хэдий чинээ байлгаваас зохих зэргийг тогтоож гүйцэтгүүлье хэмээснийг хэрхэн болговоос болхыг зөвлөн захиж ирсэн хэрэг. (*Бадаргуулт төрийн 31 дүгээр оны цагаан сарын 29. Фм 10. д 2. хн 3369. н6. х1-4. Монгол хэлээр*)
24. Хүрээний хамба шанзудба нараас Далай лам Богд гэгээнтэнийг залах ширээ тус бүр их багийг хэдий чинээ байлгаваас зохихыг тогтоож гүйцэтгүүлье хэмээн зөвлөж ирсэн хэрэг. (*Бадаргуулт төрийн 30 дугаар оны 12 сарын 29. Фм 9. д 3. хн 8240. н6. х1-11. Монгол хэлээр*)
25. Баруун Зангийн газрыг тогтоохын урьд Далай ламыг Хүрээний газарт суулгана уу хэмээн зарлигийг гуйн айлтгасныг далай ламын Жүн хамба нарт тушаах хэрэг. (*Бадаргуулт төрийн 30 дугаар оны 12 сар. Фм 1. д 1. хн 7294. н11. х1-5. Манж хэлээр*)
26. Далай лам Хүрээний газар сүм үйлдүүлж ном хуруулсугай хэмээн гуйсныг төлөө тушаасан цухалдаж айлтгасныг далай ламын Жүн хамбын зэрэг хоёр газарт тушаах хэрэг. (*Бадаргуулт төрийн 30 дугаар оны 12 сар. Фм 1. д 1. хн 7294. н36. х1-6. Манж хэлээр*)

27. Далай лам Хүрээний газарт нэгэн шинэ сүм босгож ном уншуулахад ноцтой зүйл бүхий үгүй явдлыг Жибзундамба хутагтад сонсгоод хурдан мэдэгдэж ирэх зэрэг явдлыг Хүрээний Хамба номун хан, эрдэнэ шанзудба нарт тушаах хэрэг. (*Бадаргуулт төрийн 30 дугаар оны 11 сар. Фм 1. д 1. хн 7294. н28. х1-7. Манж хэлээр*)
28. Далай ламыг угтаар ирэх сайдын хэрэглэх улаа зүйлийг бэлтгэхэд хүрээний өмнөд өртөөнд аймаг шавиас улаа зүйл хавсаран бэлтгүүлнэ үү хэмээн өргөснийг шууд хэрэгсэхгүй болгоод харъяат өртөөг захирах туслагч тайж Гончигцэрэнд тушаах хэрэг. (*Бадаргуулт төрийн 30 дугаар оны 10 сар. Фм 1. д 1. хн 7294. н23. х1-5. Манж хэлээр*)

### **Сүм Сургууль**

1. Жибзундамба хутагтын Их хүрээ, Гандандэгчилэн хүрээ, Даян хүрээ, Шашиныг бадруулагч хийд, Бишрэлт сүм, Буяныг залбирагч сүм, Дашсамдан дацанд эдүгээ тус тус хурал, сургууль үйлдэж суугаа хуврага, гэрийн нэр тоог тодорхойлон бичсэн цэс. *Б312 [1873] он 10 сарын 30. (М-1 Д-1 Хн-1720. Тал 1-149)*
2. Сайшаалт ерөөлтийн хорьдугаар оны сүүл сард Жибзундамба хутагтын эрхэмхэн алба хааж явах сойвон, гэвхүй нараас доош хаалгач, соёгба лам нар жич хар зайсан, хүлэгчин хүртэл шинэтгэн байцаагаад ван амбанд өргөсөн дэвтэр данс. *СЕ2[1797] оны сүүл сарын 27. (Т-1 Д-1 Хн-559. Тал 1-17)*
3. Хүрээний олон дуган сүм хурал номын газар олон бурхан шүтээдийн тахил зул хүж манж цав ба мөн олон газар албаа хааж явах хүн нарын хэрэглэвээс зохих эл юм зүйлийг нэгэн жилээр хураангуйлж өөр өөрийн нэрийн доор ялган салган тодорхойлж бичсэн данс. *БТ21 [1895] оны 12 сарын шинийн 7. (М-1 Д-1 Хн-2135. Тал 1-46)*

### **Хүрээг хамгаалах цэргийн тухай**

1. Юн, Бү нар хууль ёсоор авлан боловсруулах явдлыг сонсгон айлтгах тул. *ТТ60.7.9. (М-1. Д-1. Хн-527.61)*
2. Хүрээний ойролцоох Баянзүрх ууланд цэрэг боловсруулах тухай. *ТТ58.4. (М-1. Д-1. Хн-495. 102-104)*
3. Хүрээний ойролцоох Баянзүрх ууланд цэрэг боловсруулах тухай. *ТТ.57.09.15. (М-1. Д-1. Хн-495. 129)*
4. Зарлигыг дагаж боловсруулах Сэцэн хан аймгийн нэг мянган цэргүүдээс анханы ангид ирүүлсэн цэрэг, эдэнийг захирах засаг түшмэдийн нэр тооны өргөх цэс. *ТЭ10[1860] оны хаврын сүүл сарын шинийн 9. (М-1 Д-1 Хн-1430. Тал 1-15)*
5. Зарлигийг дагаж боловсруулах цэцэн хан аймгийн нэгэн мянган цэргийн дотроос эдүгээ Хонхон хэмээх газар хуруулж боловсруулах цэргүүдийг захирах гүн, түшмэдийн нэр зэрэг тоо, *Б3 тэргүүн он. Зуны сүүл сарын 26. [1862] [М-1 Д-1 Хн-1475 Тал 1-38]*
6. Бүрэнт засагчийн есдүгээр оны арван сарын шинийн хоёр нь сайд цэргийн эр, зэвсэг хураасан хуулга. *Б39 [1870] он 10 сарын шинийн 2. (М-1 Д-1 Хн-1642. Тал 1-4)*

7. Түшээт хан аймгийн дөрөвдүгээр хорооны цэргүүдийн цэс. 8 сарын 23. (М-1 Д-1 Хн-1847. Тал 1-20)
8. Түшээт хан аймгийн боловсруулах хоёр мянган цэргийг дөрвөн анги хувааж, хороо байгуулан хороо тутам үе зохиож хэрэг шийтгэх гүн, анги үе захирах түшмэд, жич эмч шавь лам нар дарга цэргүүдийн нэр зэрэг тоо бас ерөнхийлөн авах сайд, чуулганы дарга вангийн газар хэрэг туслан шийтгэх түшмэд бичигч зарлагын занги нарыг төсөвлөн тогтоож тодорхойлсон цэс. БТ6 [1880] оны 7 сарын шинийн 10. ( М-1 Д-1 Хн-1869. Тал 1-90)
9. Түшээт хан аймгийн гуравдугаар хорооны цэргүүдийн цэс. БТ6 [1880] оны 8 сарын 19. ( М-1 Д-1 Хн-1873. Тал 1-29) [25-29 хуудсанд манжаар үйлдсэн байна.]
10. Сэцэн хан аймгаас Хүрээний газар суугаа боловсруулах хоёр мянган цэргийг дөрвөн хороо болгож хороо тутам анги үе хувааж, хорооны хэргийг туслан шийтгэх гүн, анги үеийг захирах түшмэд жич эмч шавь лам дарга цэргүүдийн нэр зэрэг басхүү бүх цэргийг ерөнхийлөн захиран авах чуулнаны дарга вангийн газар хэрэг туслан шийтгэх түшмэд бичээч зарлагын занги нарыг хамтаар тодорхойлж бичсэн цэс. БТ6 [1880] оны зуны дундад сарын 16. ( М-1 Д-1 Хн-1873. Тал 1-116)

## **Хүрээнд чулуун нүүрсний уурхай нээх тухай (1900 он)**

Гүн Цэрэнгомбо хэбэй нарт өргөн тушаан илгээв. Явуулах учир эдүгээ сайдууд танай газраас тушаасан бичигт тушаан явуулах учир тамгын газрын өргөсөн нь энэ жил гурван сарын арван найманд худалдааны хэргийн яамнаас хүргэж ирсэн бичигт байцааваас бадаргуулт төрийн хорин есдүгээр оны арван нэгэн сард хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин Ляны газраас хүрээний газраа бэйс Пун-гийн хошууны чулуун нүүрс маш сайн хэрэв тэрхүү чулуун нүүрсний уурхайг нээвээс худалдааны иргэнд тустай хэмээх байтугай албан газар ашиг олох нь мөн цөөнгүй болно. Хэмээх зэргээр ирсэн тухайд манай журганаас хүрээний газраа чулуун нүүрсний уурхайг нээхэд одоо уурхайн газрыг байцаан үзүүлсэн эссэнийг тэрхүү чулуун нүүрс цөм хэрхэн болох ба хойд өдөр нээн одоход хэвээр дотоод газрын ёсоор шийтгэвээс болох үл болох эсвээс зэвсэг худалдан авч хэрэглэх, жич хэрэгсэх зүйлийн мөнгийг хэрхэн төсөвлөн цугларуулах ба албаны шийтгүүлэх эсвээс худалдааны хүнээр шийтгүүлэх ба хэрхэн болбоос тустай болох явдлыг хурдан төсөвлөн хянаж басхүү хэмжээ тогтоож манай яаманд бичиг хүргэн ирүүлж хянан байцаахад тэмдэг болгосугай хэмээн хойш захисан нь эдүгээ болтол ер байцааж хариу хүргэн ирүүлсэнгүй байцааваас баруун хойд монгол чуулган оросын захад залгалдан нийлсэн бөгөөд холбогдсон нь нэн чухал хэрэв урьд захьсан ёсоор нээн шийтгэвээс өөрсдөө ашиг бүхийн тулд худалдааны иргэнд тустай хэмээх төдийгүй уурхайн ашиг их л хөгживөөс цалин төсөвлөн цэрэг боловсруулахад нөхвөргүй хэмээх газаргүй, басхүү бусдын шүлс, гажуу салгууг битүүгээр таслан урьд нэгэн алхамыг газрыг эзлэх тул захын хэрэгт тустай газар бий. Иймийн тул хойш урагш явуулсан уг захиаг сийрүүлж үүнийг эрхэм сайдуудад явуулаад манай журганы урьд удаагийн захиаг байцаан үзэж хянан лавлалтайг төсөвлөн шийтгэж хаалга захыг баталгах бөгөөд захын иргэдэд тус болгож басхүү хурдан манай журганд хариу хүргэн ирүүлсүгэй хэмээн хүргэж ирсэн тухайд манай газраас яамны бошго Хунчиован нарыг гаргаж байцаан үзүүлээр илгээсэн хойно Цэцэн хан аймгийн гүн Цэрэнгомбын хошууны нутаг Бүс хэмээх уулын газар чулуун нүүрс буй хэмээн басхүү ухаж авсан чулуун нүүрсийг өргөн хүргэж ирүүлсэн тухайд харъяат хошуунаас хүн гаргаж энэ зүйлийн чулуун нүүрсийг бусад хүнд өчүүхэн төдий эвдүүлэн ухуулахад хүрүүлэхгүй болгон сайхнаар цагдан харгалзуулах явдлыг харъяат газар тушаасныг дансанд тэмдэглэжээ. Үүнд манай сайдууд энэ зүйлийн чулуун нүүрсийг данс үзвээс бусад газрын чулуун нүүрснээс их л сайн, нээн ухуулбаас болхын тулд үүнийг гүн Цэрэнгомбо түшмэдэд тушаагаад харъяат хошуунаас хүн гаргаж дагаж нээн шийтгүүлэн чадах эсэх ба эсвээс урьд манай сайдуудтаны газраас хүн гаргаж данс шүүлгэх ба нэгэнтэйгээр худалдааны иргэнийг элсэж дагаж шийтгүүлэх аль нэг болох явдлыг бичиг хүлээн авсан өдрөөс гурван өдрийн дотор хурдан түргэнээр манай газар тодорхойлон мэдүүлэн ирүүлэхээс гадна энэ зүйлийн чулуун нүүрсний уурхай элбэгээр гарч чадах эсэх хойч өдөр үнэ дагацуулан худалдаж хэрхэн хувь хуваан олгуулах явдлыг дараа уурхайн багш хөлслөн авч ирж тодорхойлон байцаалгасан хойно жич зохихыг үзэж хянан шийтгэвээс басхүү одоо яамны бошго Хунчиованыг дахин

томилон гаргаж чулуун нүүрс ухуулж хүрээнд тээн авч ирүүлж данс үзэхэд бэлтгүүлэх учир илгээсэнд хэвээр харъяат хошуунаас сайхнаар хамгаалуулан баримтлан захиргасугай. Үүнийг хэрлэн барс хотын чуулганы дарга нарт тушаан явуулаад уламжлан харъяат хошуунаа тушааж мөрдөн дагаж явуулсугай хэмээмүй хэмээн өргөжээ хэмээн тушаан хүрч иржээ. Иймийн тул үүнийг туслагч жанжин хэбэй танд явуулаад байцаан үзүүлэхээс гадна басхүү гүн Цэрэнгомбо нарт тушаан явуулаад бичгийн доторх хэргийг хянан үзэж энэ зүйлийн чулуун нүүрсийг харъяат хошуунаас хүн гаргаж дагаж нээн шийтгүүлэн чадах эсэх зэрэг явдлыг тодорхойлон мэдүүлэх ба мөнхүү чулуун нүүрсийг сайнаар цагдан харгалзуулах явдлыг цөм уг тушаасан ёсоор мөрдөн дагаж шийтгүүлсүгэй. Үүний тул өргөн/тушаан илгээв.

Гучин хоёрдугаар он илүү дөрвөн сарын хорин долоон

*Түүхийн хүрээлэн, Хөмрөг 1. ᠔-1. хн-708.*

### **Орос Лушниковт худалдааны газар олгуулах тухай**

Мэдтүгэй хэмээх учир,

Эдүгээ эрхэм генералный консул сайдаас Хүрээний баруун этгээдэд суусан харъяат Оросын худалдааны хүн Лушников хэмээх Доржид нэгэн жижиг хашаа нэмж барих газар заан олгуулна уу хэмээн хэлмэрчийг зарж хэлж ирсэн учирт манай газраас тэр орос худалдааны хүнд хашаа барих газар олгуулахад татгалзалтай явдал бүхий үгүй зэргийг байцаан үзээд мэдэгдэж ирэх тул гаргасан харъяат гурван газрын түшмэд, зайсан нараас тушаасныг дагаж Орос хэлмэрч занги Цэрэнпилийн хамт яваад Орос худалдааны хүн Лушников хэмээх Доржид хашаа босгох газрыг байцаан үзвээс урьд орос занги Цэрэнпилд олгуулсан газрын баруун этгээдэд залган хөндлөн зүүнээс дөрвөн хос алд, хойноос урагш арван хоёр хос алд сул газар олгуулахад зам зүй зэрэгт татгалзах газаргүй хэмээн газрын байдал төлвийг зураг зурж тогтоохыг гуйж өргөжээ. Байцааваас харъяат гаргасан түшмэд энэ хэргийн Орос худалдааны хүн Лушников хэмээх Доржид бага хашаа босгох газар олгуулахад татгалзалтай явдал үгүй хэмээн тодорхойлон мэдэгдсэн учирт манай сайд хоёр улсын бат найрамдууг бодож энэ удаа ёсоор болгосон тул үүнийг Хүрээнд суусан Оросын хэргийг бүгд эрхлэн захирах дээд генералый консул сайдад найрамдуу сайны ёсоор явуулахаас гадна үүнээс хойш энэ мэт хэрэгт зүйгээр албан бичиг хүргэж ирээд тогтооход бэлтгүүлвээс зохих явдлыг хамтаар явуулсугай. Үүний тул найрамдуу сайны ёсоор мэдтүгэй хэмээн илгээв.

Бадаргуулт төрийн хорин дөрөвдүгээр оны зургаан сар

*Манж хэлээр. М1.Д1. ХН2191. Т22-23.*